

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны ... дугаар  
сарын ... -ний өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Хот байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэл Улаанбаатар хотын хүн амын хэт төвлөрөл, хүрээлэн буй орчинд үзүүлж буй агаар, ус, хөрсний бохирдол, сөрөг нөлөөг бууруулах, эдийн засгийн тодорхой салбаруудыг тогтвортой хөгжлийн зорилтуудад нийцүүлэн хөгжүүлэх, хүн амыг эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Аэросити” болон “Майдар” шинэ хотуудыг Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт байгуулсугай.

2. “Аэросити”, “Майдар” хотуудыг байгуулахтай холбогдуулан холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ж.Ганбаатар/-нд даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ